



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/649

Мөрөн сум

Эргүүл, хяналт шалгалтын ажилд
бусад байгууллагыг татан оролцуулан
ажил эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.2, Автозамын тухай хууль 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.5 дахь заалт, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын “Могойн гол” ХК-ийн уурхайгаас нүүрс тээвэрлэлтийг гүйцэтгэхдээ даац хэтрүүлэн, авто зам, замын байгууламжид эвдрэл гэмтэл учруулж, олон салаа зам гарган, байгаль орчныг бохирдуулж, зохицуулалтгүй тээвэрлэлт гүйцэтгэж байгаа талаар иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэх зорилгоор эргүүл, хяналт шалгалтын ажлыг 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрөөс 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулсугай.

2.Хяналт шалгалтын үйл ажиллагаанд албан хаагчдаа томилж ажиллахыг Хөвсгөл аймгийн Цагдаагийн газрын дарга (Цагдаагийн хурандаа Д.Мөнхжаргал), Байгаль орчны газрын дарга (П.Мөнхжаргал), Автотээврийн төвийн дарга (Ө.Баттулга), Эрүүл мэндийн газрын дарга (М.Үүрийнбаяр), Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга (Д.Батцоож) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Удирдлага зохион байгуулалтаар хангаж, шаардлагатай арга хэмжээг тухай бүрт авч ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа)-д, хяналт шалгалтын ажилд шаардагдах санхүүжилтийг холбогдох журмын дагуу аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар, Төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар)-т тус тус үүрэг болгосугай

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Гансүх)-д даалгасугай.

ОРЛОГЧ



Ц.ГАНСҮХ

Захирамж2024

6712012060